

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ БАЯНХОНГОР НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ЗАЙНААС ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2022.09.30

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын баталсан 2022 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн ИНЕГ-ын харьяа зарим нисэх буудлын үйл ажиллагаанд зайнаас дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 09/22 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны менежер Ө.Мөнгөнжигүүр, аудитор А.Мөнх-Эрдэнэ, Ц.Оюут, О.Сэндэр нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2022 оны 8 дугаар сарын 22-ны өдрөөс 2022 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийг дуусталх хугацаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Баянхонгор нисэх буудлын 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 7 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацааны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэл, цалин хөлсний бодолт, олголт, төсөв гүйцэтгэл, дотоод хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус багийн үйл ажиллагаа, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Баянхонгор нисэх буудлын 2021 оны 4 дүгээр сараас 2022 оны 7 дугаар сарын дуусталх хугацааны цалингийн тооцоог ажилтнуудын ээлжийн амралтын хоног, ажилласан хоногтой тулгахад 2 ажилтанд ээлжийн амралтын цалин, цалин хөлс нь 1-ээс 4 хоног давхар бодогдож 461,317.5 төгрөгийг бодож олгосон.

Тус нисэх буудлын бараа материалын бүртгэл хөтлөлтийг шалгахад ИНЕГ-ын НБББББ-ийн 4.3-т заасан Бараа материалын бүртгэлийн А-д заасан бараа материалын гүйлгээг бүртгэх журналын бичилтийг зөрчиж 2022 оны эхний 7 сард 2 ажил гүйлгээнд 2.1 сая төгрөгийн худалдан авалтад НӨАТ-ын авлага үүсгээгүй зөрүүтэй бүртгэсэн.

2021-2022 онд гарсан 69 тушаалын 15 нь үг үсэг, утга найруулгын алдаатай бөгөөд холбогдох журмын заалтуудыг зөрчсөн. Нисэх буудлын даргын 2022 оны А/09 дүгээр тушаал нь Иргэний нисэхийн тухай хуульд нийцээгүй.

Тус нисэх буудлын агаарын хөлгийн техникч-1, хамгаалалтын ажилтан-1, аюулгүй байдлын үзлэгийн шалгагч-1, нийт 3 ажилтан нь албан тушаалын тодорхойлолтын мэргэшлийн шаардлагыг хангаагүй.

Тус нисэх буудлын ажиллагсдын цаг бүртгэл хариуцсан ажилтан нь ажиллагсдын цагийн бүртгэлийг Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу цахим системээр бүртгэдэггүй.

Тус нисэх буудалд ашиглаж буй ... дизель генераторт шатахуун зарцуулахдаа ажилласан мото.цагтай тулгаагүй зардалд бүртгэсэн нь ИНЕГ-ын НБББББ-ын 4.3.2-т заасан Бараа материалын бүртгэлийн горимд заасан баримтыг бүрдүүлээгүй, тухайн ажил гүйлгээ гарсныг нотлох, баримтжуулах ажил хангалтгүй хийгдсэн бөгөөд зардалд тусгасан.

Баянхонгор нисэх буудалд ашиглагдаж буй автомашинуудын спидометрийн заалтыг жолоочийн тооцооны хуудсанд тэмдэглэдэггүй, түүнчлэн 1526 УБС улсын дугаартай SONATA-5 мөн 4951 БНА улсын дугаартай УАЗ маркын 2 автомашины спидометрийн заалт ажиллахгүй байна.



Дотоод аудит, хяналт шалгалтын хамрагдах хугацаанд 2021 онд 11, 2022 онд 13, нийт 24 гэрээ байгуулсан нь бүгд “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын зарим заалтуудыг зөрчсөн байна.

Тус аймагт байрлалтай ИНЕГ-ын эзэмшлийн нийт 8 орон сууц байдаг ба тэдгээрийн 3 орон сууцыг түр хугацаагаар эзэмшүүлж буй нь Хөдөлмөрийн дотоод журам болон Албаны орон сууц эзэмшүүлэх гэрээний холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Тус нисэх буудлын 2022 онд зохион байгуулсан 2 тендер шалгаруулалтыг шалгахад аймгийн засаг даргын тамгын газарт зохион байгуулсан боловч үнэлгээний хороонд нисэх буудлаас оролцоогүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47.3-т заасан шаардлагыг хангаагүй, мөн шалгах өдрийн байдлаар тухайн нисэх буудалд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн гэрчилгээтэй 1 ажилтан ажиллаж байгаа нь худалдан авах ажиллагааг ил тод зохион байгуулах боломжгүй, тендер шалгаруулсан тухай хавтаст хэрэг үйлдээгүй байна.

Шилэн дансны цахим системд 2022 оны 02 дугаар сард 1 мэдээлэл байршуулаагүй байсныг аудит, хяналт шалгалтын хугацаанд 2022 оны 08 дугаар сарын мэдээлэлд нөхөн мэдээлсэн.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар Баянхонгор аймаг дахь Баянхонгор нисэх буудалд 13 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА